



ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2023 оны 08 сарын 16 өдөр

Дугаар 02

Ховд

Хөдөө аж ахуйн салбарын болон хот, төв суурин
газрын 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангах тухай

Мал аж ахуйн өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг хангах, хадлан тэжээл бэлтгэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "Л" заалт, Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 07 дугаар сарын 19-ний өдрийн 279 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ДААЛГАХ нь:

Нэг. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах чиглэлд сум, багийн Засаг дарга, Хөдөө аж ахуйн салбарын мэргэжилтэн нарт:

1.1. Сумдын бэлтгэвэл зохих өвс, тэжээлийн аюулгүйн нөөц, малчдын түвшинд бэлтгэвэл зохих өвс, тэжээл, хужир шүүний хэмжээг хавсралтаар баталсугай.

1.2. 2023-2024 оны өвөлжилтийн бэлтгэл хангуулах сум, багийн ажлын хэсгийг 2023 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор багтаан томилж, хийх ажлын талаар нарийвчилсан төлөвлөгөө гаргаж, хэрэгжилтийг хангуулах, ажлын явц биелэлтэд хяналт тавьж, шаардлагатай арга хэмжээг холбогдох газар, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хэрэгжүүлэх.

1.3. Сум бүр цаг агаарын аюултай үзэгдлийн үед гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангуулах.

1.4. Малчин, мал бүхий иргэд байгалийн хадлан, гар тэжээл, хужир шүү бэлтгэх ажлыг технологит хугацаанд нь чанартай гүйцэтгүүлж, сумдын өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудыг татан оролцуулж, нийт малын 30 хувийг 1 хоног тэжээхээр тооцон бэлтгэх, шаардлагатай цэгүүдэд байршуулах арга хэмжээ авах.

1.5. Хадлан тэжээл бэлтгэх техникийн бүрэн бүтэн байдлыг хангах, засвар үйлчилгээг энэ оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор дуусгах, хадлан тэжээл бэлтгэх багаж, тээврийн хэрэгслээр хангах ажлыг орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан зохион байгуулах.

1.6. Өөрийн сумын нутгаас өвс бэлтгэх боломжгүй сумууд хадлангийн нөөц талбай бүхий бусад сумдын удирдлагатай 08 дугаар сарын 20-ны өдрөөс өмнө хадлангийн талбайг

840002 0006
2023 AD/02 Ba

ашиглах, өвс бэлтгүүлж худалдан авах гэрээ байгуулж өвс, тэжээлийн нөөцийг бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

1.7. Өвөл, хаврын бэлчээрийн даацад тулгуурлан өөр аймгийн болон өөрийн аймгийн бусад сумдын нутаг, сум дундын болон аймаг дундын отрын бүс нутгууд, хилийн зурвас газар, улсын тусгай хамгаалалттай газруудад өвөлжих, хаваржих өрх, малын тоог 08 дугаар сарын 20-нд урьдчилан гаргаж аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газарт ирүүлэх, отроор өвөлжих, хаваржих сумдын удирдлагуудтай гэрээ хэлцлийг 09 дүгээр сард багтаан зохион байгуулах, бүс алгасаж нүүдэл хийхгүй байхад анхаарах.

1.8. Отор нүүдлээр явж байгаа малчдыг хүн, мал эмнэлгийн байгууллагад бүртгүүлэх, холбогдох мэргэжлийн байгууллагаас тусламж үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай эд материалын хангамжийг нэмэгдүүлэх, уялдаа холбоог хангах ажлыг зохион байгуулах.

1.9. Малын гоц халдварт, халдварт, паразиттах өвчин, ариутгал, халдваргүйжүүлэлтийн арга хэмжээг технологит хугацаанд нь чанартай зохион байгуулах, мал, мах, малын гаралтай түүхий эд бүтээгдэхүүнд мал эмнэлгийн гэрчилгээ олгохдоо вакцинжуулалт, тарилга, туулгалтын хугацааг сайтар хянах, мал эмнэлгийн дуудлага, үйлчилгээний бэлэн байдлыг бүрдүүлж, шуурхай удирдлагаар хангаж ажиллах.

1.10. Малчин өрх бүрийг малын хашаа, саравч, уст цэгээ засварлах, тохижуулах, түлээ түлшээ бэлтгэх, цаг агаар хүндэрсэн нөхцөлд хэрэглэх өвс, тэжээл, гар тэжээлийг нөөцлөх, өвлийн хувцас хэрэглэл, хоол хүнсээ базаах зэргээр өвөлжилтийн бэлтгэлийг сайтар хангуулах.

1.11. Нийт хээлтэгч, хээлтүүлэгч малын тохироог бүрдүүлж, дутагдалтай хээлтүүлэгчийг нөхөн тавих хуц, ухныг 12 дугаар сарын 10-ны өдрийн дотор багтаан ялгаж, малчдын саналын дагуу суурь зохион байгуулж ажиллах.

1.12. Сумын өвөл, хаврын бэлчээрийн даацыг бодитой тогтооход анхаарч ажиллах, сум, багийн харилцаа холбооны найдвартай ажиллагааг хангаж, цаг агаарын гамшигт үзэгдлийн талаарх урьдчилан сэргийлэх мэдээ, мэдээллийг иргэд, малчдад тогтмол хүргэж байх.

1.13. Намрын ургац хураалтад шаардагдах хүн хүч, техникийн бүрэн бүтэн байдал, хүрэлцээ хангамж, шатах тослох материалын нөөц бүрдүүлэхэд анхаарч, ургацыг хаягдал багатай хураан авах, хадгалах байр сав бэлтгэх.

1.14. Мал, мах бэлтгэх ажлыг эрчимжүүлэх, дундаас доош тарга хүчтэй эр, сувай малын 50 хүртэлх хувийг эдийн засгийн эргэлтэд оруулах, малыг бордож борлуулах, энэ ажилд мал, мах бэлтгэдэг компани, бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжтэй холбоо тогтоон гэрээ байгуулах замаар газар дээр нь борлуулах ажлыг зуучлан зохион байгуулах.

Хоёр. Хот, төв суурин газрын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл хангах чиглэлд аймгийн Засаг даргын тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн), Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), мэргэжлийн байгууллагуудын дарга,

эрхлэгч, аж ахуй нэгж, байгууллагуудын удирдлагуудад.

2.1. Албан байгууллага, айл өрхүүдийн дулааны шугам сүлжээний урсгал болон их засварын ажлыг 08 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор бүрэн хийж дуусган шалгаж, хүлээн авах.

2.2. Жилийн хэрэгцээний түлш, нүүрсний 40-өөс доошгүй хувийн татан авалтыг сум, байгууллага, дулааны станц бүрээр бүрэн тооцож 09 дүгээр сарын 15-ны өдрийн дотор татан авч нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулах.

2.3. Барилга байгууламжуудын урсгал болон их засварын ажлуудыг 09 дүгээр сарын 01-ний өдрийн дотор дуусгаж, хаалга цонх, гадна худаг, засвар үйлчилгээг хийлгэн хүлээн авах.

2.4. Улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй барилга угсралт, их засварын ажилд хяналт хийж, зөвлөн туслах ажлын хэсгийн хуваарийг гаргаж ажиглагч байгууллагуудын дотоод хяналтыг тогтмол хийлгэж чанарт нь онцгой анхаарч ажиллах.

2.5. Сум, байгууллага, айл өрхийн цахилгаан шугам сүлжээний засвар үйлчилгээг 08 дугаар сард багтаан хийх талаар иргэн, аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах.

2.6. Аж ахуй нэгж, байгууллага, айл өрхийн ус хангамж, ариутгах татуургын ашиглалт, засвар үйлчилгээг 08 дугаар сард багтаан хийх талаар иргэн, аж ахуй нэгжүүдтэй хамтран ажиллах.

Гурав. Өвөлжилт, хаваржилтын бэлтгэлийг бүрэн хангах, дэмжлэг үзүүлж, хяналт тавих, мэдээ тайлан ирүүлэх талаар:


3.1. Энэхүү албан даалгаврын заалт бүрийн хэрэгжилтийг цаг хугацаанд нь хангаж, явцын мэдээ тайланг тухай бүр нь аж ахуй нэгж, байгууллага, иргэд, олон нийтэд сурталчилж ажиллахыг сум, байгууллагуудын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.2 Өвөлжилт, хаваржилт хүндэрсэн, хүндэрч болзошгүй үед зам даваа хаагдах, малчдад өвс, тэжээл, эм эмчилгээний хэрэгсэл, өргөн хэрэглээний болон хүнсний бараа бүтээгдэхүүн хүргэх, цаг агаарын мэдээ, мэдээллийг шуурхай дамжуулах ажлын бэлэн байдлыг хангаж ажиллахыг аймгийн Эрүүл мэндийн газар, Ус цаг уур, орчны шинжилгээний газрын дарга нарт үүрэг болгосугай.

3.2. Хөдөө аж ахуйн салбарын өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөө, зөвлөмжөөр ханган, тулгамдаж буй асуудлуудыг шуурхай шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж, явцын мэдээг 08 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн 7 хоног тутамд Хүнс, хөдөө аж ахуйн газарт хүргүүлэхийг сумдын Засаг дарга нарт, нэгдсэн дүнг 10 дугаар сарын 15-ны өдрөөр тооцон аймгийн аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах, тогтоосон хугацаанд хавсралтаар баталсан аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг бүрдүүлээгүй сумдын Засаг дарга нарт хариуцлага тооцож ажиллахыг Засаг даргын тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн)-д даалгасугай.

3.3. Хот, суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах төлөвлөгөөт ажлын хэрэгжилтийн явцад тогтмол хяналт тавьж, явцын мэдээг иргэдэд тогтмол хүргэж, дүнг нээлттэй танилцуулж байхыг аймгийн Засаг даргын тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Б.Баярсүх), нэгдсэн дүнг 2023 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулахыг Засаг даргын тамгын газрын дарга (Б.Сандагсүрэн) нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Т.ДЭЛГЭРСАЙХАН

Аймгийн Засаг даргын 2023 оны
08 дугаар сарын 16-ны өдрийн
02 дугаар албан даалгаврын хавсралт



ХАДЛАН, ТЭЖЭЭЛ, ХУЖИР ШҮҮ БЭЛТГЭХ НӨӨЦЛӨХ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Сумын нэр	Бэлтгэх хадлан (тн)	Бэлтгэх гар тэжээл (тн)	Бэлтгэх хужир шүү (тн)	Сумын аюулгүй нөөцөд бэлтгэх	
					Өвс (тн)	Тэжээл (тн)
1	2	3	4	5	6	7
1	Алтай	1500	150	500	50	30
2	Булган	20000	350	840	50	30
3	Буянт	8000	250	600	50	30
4	Дарви	800	200	500	50	30
5	Дөргөн	1200	100	400	50	30
6	Дуут	100	50	300	50	30
7	Зэрэг	3000	250	400	50	30
8	Манхан	2500	200	550	50	30
9	Мянгад	6000	200	650	50	30
10	Мөст	100	50	450	50	30
11	Мөнххайрхан	100	50	260	50	30
12	Үенч	5000	250	370	50	30
13	Ховд	5500	250	480	50	30
14	Цэцэг	100	100	360	50	30
15	Чандмань	1500	200	620	50	30
16	Эрдэнэбүрэн	2500	250	420	50	30
17	Жаргалант	700	100	300	50	30
18	Дүн	58600	3000	8000	850	510
19	Аймгийн дүн				150	50
20	Аймгийн нэгдсэн дүн	58600	3000	8000	1000	560

-оОо-